



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 4 (529)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай*
- *Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Нийгмийн халамжийн тэтгэвэрийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2008 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны нэгдүгээр сарын 28

№4 (529)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

63.	Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай	69
64.	Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	74

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

65.	Нийгмийн халамжийн тэтгэвэрийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай	Дугаар 02	75
66.	Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 03	75
67.	Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 04	76

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

68.	Улсын дээд шүүхийн захиргааны танхимийн тэргүүнийг томилох тухай	Дугаар 11	76
-----	--	-----------	----

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

69.	Хүнсний аюулгүй байдлыг хангах, архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 04	76
-----	--	-----------	----

### Тав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

70.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 43	77
71.	Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 44	81
72.	Захиргааны хариуцлагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 45	82
73.	Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай	Дугаар 46	84

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хүн ам, орон сууцны улсын ээлжит болон завсрын тооллого зохион байгуулж явуулахтай холбогдсон зарилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсын Үндсэн хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт хэвлэгдсэн. Статистикийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны 7 дугаарт хэвлэгдсэн. Архивын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 2 дугаарт хэвлэгдсэн.

#### 2 дугаар зүйл. Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль тогтоомж

2.1. Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Статистикийн тухай хууль<sup>2</sup>, Архивын тухай хууль<sup>3</sup>, Байгууллагын нууцын тухай

хууль<sup>1</sup>, Хувь хүний нууцын тухай хууль<sup>2</sup> болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан уггаар ойлгоно:

3.1.1. "хүн ам, орон сууцны улсын тооллого" /цаашид "тооллого" гэх/ гэж энэ хуульд заасан тооллогын хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа нийт хүн ам буюу тооллогод хамрагдах нутаг дэвсгэр дэх хүн амыг хамруулан хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн хүрээний мэдээллийг цуглуулах, боловсруулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, тооллогын үр дүнг тараах цогц үйл ажиллагааг;

3.1.2. "тооллогын төв" гэж тооллого явуулах хугацааны эхний өдөрт шилжих шөнийн 00 цагийг;

3.1.3. "тооллогын нэгж" гэж хувь хүн, түүний амьдарч байгаа байр, орон сууцныг;

3.1.4. "тооллогын ажилтан" гэж энэ хуулийн 13.5.2-т заасан тооллогын комиссын гишүүн, тэдгээрт гэрээгээр ажиллаж байгаа түр ажилтныг.

### 4 дүгээр зүйл. Тооллого зохион байгуулж явуулах арга

4.1. Тооллого зохион байгуулж явуулахад дараахь аргыг ашиглана:

4.1.1. тооллогын хугацаанд хүн амыг нэг бүрчлэн тоолох уламжлалт арга;

4.1.2. хүн амын регистрийн бүртгэлд суурилсан бүртгэлийн арга;

4.1.3. түүвэр судалгааны арга.

### 5 дугаар зүйл. Тооллого явуулах зарчим

5.1. Тооллогыг дараахь зарчмаар явуулна:

5.1.1. хүн бүрийг нэг бүрчлэн тоолох;

5.1.2. тооллогын хугацаанд тооллогод хамрагдах нутаг дэвсгэрт нэгэн зэрэг тоолох;

5.1.3. тооллогын мэдээлэл нийтлэг, иж бүрэн байх;

5.1.4. тооллогыг тогтмол, давтамжтай явуулах.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ

#### Тооллого зохион байгуулж явуулах эдийн засгийн баталгаа

6 дугаар зүйл. Тооллого зохион байгуулж явуулахад гарах зардал, түүний санхүүжилт

6.1. Тооллого зохион байгуулж явуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

6.1.1. ажилгүй болон тэтгэвэрт байгаа хүнийг статистикийн асуудал эрхэлсэн төв байгууллагад тооллогын ажилтнаар ажиллуулсан хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгох цалин хөлс;

6.1.2. энэ хуулийн 6.1.1-д заасан тооллогын ажилтныг сургах сургалтын болон тооллогын талаар олон нийтэд хүргэх мэдээлэл, сурталчилгааны зардал;

6.1.3. тооллогын ажилтны үнэмлэх, тооллого явуулах журам, тооллогын асуулгын хуудас, асуулгын хуудсыг бөглөх заавар, тооллогын дүн, мэдээний маягт зэргийг хэвлэх, тэдгээрийг тооллогын комисст хүргэх, тооллогын асуулгын хуудсыг татаж авах зардал;

6.1.4. тооллогын байгууллагын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал;

6.1.5. Улсын Их Хурлаас тогтоосон бусад зардал.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг Улсын Их Хурал тухай бүр тогтооно.

6.3. Тооллого зохион байгуулж явуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ:

6.3.1. ажилгүй болон тэтгэвэрт байгаа хүнийг тооллогын ажилтнаар ажиллуулсан хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгох цалин хөлс;

6.3.2. энэ хуулийн 6.3.1-д заасан тооллогын ажилтнуудыг сургах сургалтын болон тооллогын талаар нутаг дэвсгэрийн оршин суугчдад хүргэх мэдээлэл, сурталчилгааны зардал;

6.3.3. тооллогын хугацаанд тооллогын ажилтнуудад өгөх хоолны мөнгө;

6.3.4. хууль тогтоомжид заасан бусад зардал.

6.4. Энэ хуулийн 6.3-д хэсэгт заасан орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухай бүр тогтооно.

6.5. Тооллого зохион байгуулж явуулах комиссын ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, холбогдох төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

6.6. Энэ хуулийн 6.1.1, 6.3.1-д зааснаас бусад хүнд тооллогын ажилтнаар ажилласан хугацааны цалинг сарын дундаж цалингийн нь хэмжээгээр

<sup>1</sup> Байгууллагын нууцын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт хэвлэгдсэн.

<sup>2</sup> Хувь хүний нууцын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт хэвлэгдсэн.

тооцож тухайн хүний ажилладаг байгууллага, аж ахуйн нэгж нь олгоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Тооллогын төрөл, хугацаа, хамрах хүрээ

#### 7 дугаар зүйл. Тооллогын төрөл

7.1. Тооллого нь дараахь төрөлтэй байна:

7.1.1. 10 жил тутамд улс орон даяар явуулах ээлжит тооллого;

7.1.2. ээлжит тооллого хооронд 5 жил тутамд явуулах завсрын тооллого.

#### 8 дугаар зүйл. Ээлжит тооллогын хугацаа, хамрах хүрээ

8.1. Ээлжит тооллогыг 2010 оноос эхлэн 10 жил тутамд нэг удаа улсын хэмжээнд явуулна.

8.2. Тооллогын товгыг ээлжит тооллого явуулах хугацаанаас хоёроос доошгүй жилийн өмнө Улсын Их Хурал зарлана.

8.3. Ээлжит тооллогын хүн, ам орон сууцыг тоолох ажиллагааг товлосон өдрөөс эхлэн долоо хоногт багтаан явуулна.

8.4. Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, гэнэтийн бусад аюул тохиолдсон, дайны болон нийтийн эмх замбараагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлийн улмаас тооллогыг хугацаанд нь явуулах боломжгүй болсон бол энэхүү онцгой нөхцөл арилмагц тооллогын Улсын комиссын саналыг үндэслэн, Улсын Их Хурал тооллогын товгыг өөрчлөн тогтоож, энэхүү тогтоосон хугацаанд явуулна.

#### 9 дүгээр зүйл. Завсрын тооллогын хугацаа, хамрах хүрээ

9.1. Завсрын тооллогын тов, үргэлжлэх хугацаа, хамрах хүрээг Үндэсний статистикийн хороо тухай бүр тогтооно.

9.2. Завсрын тооллого нь ээлжит тооллогын мэдээллийг тодотгох, шинэчлэн өргөжүүлэх зорилготой хүн ам зүй, эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн дэлгэрэнгүй судалгаа хэлбэртэй байна.

#### 10 дугаар зүйл. Тооллогын нэгж

10.1. Хүн амын тооллогод дараахь хувь хүнийг хамруулна:

10.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа Монгол Улсын иргэн;

10.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт 183 хоногоос дээш хугацаатай оршин сууж байгаа

болон оршин суухаар эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан гадаадын харьяат иргэн, харьяалалгүй хүн;

10.1.3. гадаадад оршин суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, түүний гэр бүл;

10.1.4. гадаадад ажиллаж, суралцаж байгаа болон хувийн хэргээр оршин суугаа Монгол Улсын иргэн.

10.2. Орон сууцны тооллогод дараахь байр, орон сууцыг хамруулна:

10.2.1. сууцны тусдаа байшин;

10.2.2. нийтийн зориулалттай орон сууцны барилгын доторх сууц;

10.2.3. бүх төрлийн гэр;

10.2.4. нийтийн байр;

10.2.5. сууцны бус зориулалттай бусад байр, талбай.

#### 11 дүгээр зүйл. Тооллогын мэдээллийн үзүүлэлт

11.1. Тооллогын мэдээлэлд дараахь үндсэн үзүүлэлтүүд хамаарна:

11.1.1. хүн ам зүй, нийгмийн үзүүлэлт:

а/ овог, эцэг/эх/-ийн нэр, нэр;

б/ төрсөн он, сар, өдөр;

в/ нас, хүйс;

г/ яс үндэс;

д/ иргэний харьяалал;

е/ боловсрол, бичиг үсгийн мэдлэг;

ө/ шашин шүтлэг;

11.1.2. газар зүй, шилжих хөдөлгөөний үзүүлэлт:

а/ төрсөн газар;

б/ байнга болон тооллогын үед оршин суугаа газар;

в/ тухайн газарт оршин суугаа хугацаа;

г/ тооллогоос 5 жилийн өмнө оршин сууж байсан газар;

11.1.3. эдийн засгийн үзүүлэлт:

а/ ажил эрхлэлтийн байдал;

б/ эрхэлдэг ажил;

в/ эрхэлдэг аж ахуйн үйл ажиллагааны үндсэн чиглэл;

г/ ажилгүйдэл, түүний шалтгаан;

11.1.4. орон сууцны нөхцөлийн үзүүлэлт:

а/ сууцны төрөл, өмчлөл;

б/ өрөөний тоо, сууцны талбай;

в/ гал тогооны өрөө;

г/ усан хангамж, онгоц, шүршүүрийн өрөө;

д/ хог зайлуулалт, бие засах газар;

е/ цахилгаан, дулаан, харилцаа холбооны хангамж.

11.2. Энэ хуулийн 11.1-д зааснаас бусад хүн ам зүй, шилжих хөдөлгөөн, нийгэм, эдийн засгийн болон орон сууцны нөхцөлийн судалгаанд шаардагдах нэмэлт үзүүлэлтийг тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан Үндэсний статистикийн хороо тооллогын мэдээлэлд нэмж тусгаж болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Тооллогын зохион байгуулалт

**12 дугаар зүйл. Тооллого зохион байгуулж явуулах байгууллага**

12.1. Үндэсний статистикийн хороо бүтэцдээ тооллогын асуудал дагнан хариуцсан, байнгын ажиллагаатай, мэргэжлийн нэгжтэй байна.

12.2. Үндэсний статистикийн хорооны энэ зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан нэгж нь тооллогын болон тооллого хоорондын судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, гүнзгийрүүлсэн судалгаа, тооцоо хийх, мэдээллийг нийтэд мэдээлэх өсөн нэмэгдэж байгаа мэдээллийн хэрэгцээ, шаардлага болон үндэсний хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд мониторинг хийх, хүн ам болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн хамаарлыг судлах чиг үүрэгтэй байна.

**13 дугаар зүйл. Ээлжит тооллого зохион байгуулж явуулах байгууллага, түүний эрх хэмжээ**

13.1. Ээлжит тооллогыг тооллогын улсын комисс /цаашид "Улсын комисс" гэх/ Үндэсний статистикийн хороо, энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллагын оролцоотойгоор зохион байгуулж явуулна.

13.2. Улсын Их Хурал ээлжит тооллого явуулах хугацаанаас хоёроос доошгүй жилийн өмнө Улсын комиссыг Үндэсний статистикийн хорооны санал болгосноор дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

13.3. Тооллогын дүнг Улсын Их Хуралд танилцуулснаар Улсын комисс татан буугдсанд тооцно.

13.4. Энэ хуулийн 13.2-т заасан Улсын комиссын нарийн бичгийн дарга нь дараахь шаардлагыг хангасан байна.

- 13.4.1. төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан;
- 13.4.2. гадаад хэлний зохих мэдлэгтэй;
- 13.4.3. эдийн засгийн дээд боловсролтой;
- 13.4.4. Монгол Улсын иргэн.

13.5. Улсын комисс нь дараахь бүрэн эрхтэй:

13.5.1. тооллого зохион байгуулж явуулах аргыг сонгож, тооллогыг төлөвлөгөөний дагуу хугацаанд нь, үр дүнтэй зохион байгуулах;

13.5.2. аймаг, нийслэл, сум, дүүрэгт болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тооллогыг зохион байгуулж явуулах чиг үүрэгтэй комисс /цаашид "тооллогын комисс" гэх/-ыг байгуулж ажиллуулах;

13.5.3. тооллогын комиссын ажиллах журмыг батлах;

13.5.4. тооллогын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, хэрэгжилтийг хангах;

13.5.5. тооллого зохион байгуулж явуулах асуудлаар засаг захиргааны нэгж дэх төрийн зохих шатны байгууллагын үйл ажиллагааг зохицуулах;

13.5.6. шаардлагатай гэж үзвэл тооллого зохион байгуулж явуулахтай холбогдсон асуудлаар тооллогын комиссын мэдээлэл сонсох, тооллоготой холбоотой аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох арга хэмжээ авах;

13.5.7. тооллогын бэлтгэл ажлын хүрээнд болон тооллогын явцад тооллогын комисст нэгдсэн удирдамж, чиглэл өгөх;

13.5.8. тооллогын дүнг хэлэлцэж баталгаажуулан, Улсын Их Хуралд танилцуулах;

13.5.9. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

13.6. Үндэсний статистикийн хороо нь ээлжит тооллогын үед Улсын комисст мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй бөгөөд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13.6.1. тооллогыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж явуулах;

13.6.2. Улсын комисс, түүний гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

13.6.3. Улсын комиссын шийдвэрийн төсөл боловсруулж хэлэлцүүлэх;

13.6.4. Улсын комиссын хуралдааны бэлтгэл хангах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, гаргасан шийдвэрийг хэлбэржүүлэх, нийтлэх, мэдээлэх;

13.6.5. тооллогын асуулгын хуудас, тооллогын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх аргачилсан заавар, зөвлөмж батлах, асуулгын хуудсыг хэвлүүлэх, хуваарилах;

13.6.6. тооллогын дүнг нэгтгэж, Улсын комисст оруулах;

13.6.7. тооллогын мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, үр дүнг хэрэглэгчдэд мэдээлэх;

13.6.8. шаардлагатай сургалт, сурталчилгаа явуулах;

13.6.9. хууль тогтоомжид заасан болон Улсын комиссоос үүрэг болгосон бусад чиг үүрэг.

13.7.Тооллогын комисс нь энэ хуулийн 13.5.2-т заасны дагуу байгуулагдах бөгөөд дараахь үүрэгтэй:

13.7.1.тооллогоор хүн ам, орон сууцны талаархи мэдээллийг зохих журмын дагуу тухайн нутаг дэвсгэртээ цуглуулах ажлыг зохион байгуулах;

13.7.2.тооллогын ажилтныг гэрээгээр авч ажиллуулах, шаардлагатай сургалт явуулах, ажлын нь үр дүнг тооцох;

13.7.3.Улсын комисс болон Үндэсний статистикийн хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;

13.7.4.тооллогын мэдээллийн үзүүлэлтийг нэгтгэж, дээд шатны байгууллагад хүргэх;

13.7.5.бусад үүрэг .

**14 дүгээр зүйл. Завсрын тооллого зохион байгуулж явуулах байгууллага, түүний эрх хэмжээ**

14.1.Завсрын тооллогыг Үндэсний статистикийн хороо зохион байгуулж явуулна.

14.2.Үндэсний статистикийн хороо нь завсрын тооллого явуулах талаар дараахь бүрэн эрхтэй:

14.2.1.тооллого зохион байгуулж явуулахтай холбоотой нэгдсэн удирдамж, чиглэлийг холбогдох байгууллага, комисст өгөх;

14.2.2.энэ хуулийн 13.5.1, 13.5.4-13.5.6, 13.6.1, 13.6.5, 13.6.7, 13.6.8-д заасан бүрэн эрх;

14.2.3.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## ТАВДУГААР БҮЛЭГ

**Тооллого зохион байгуулж явуулахад төрийн болон орон нутгийн байгууллага, иргэдийн оролцоо**

**15 дугаар зүйл. Тооллого зохион байгуулж явуулахад төрийн захиргааны төв байгууллагын эрх хэмжээ**

15.1.Дараахь төрийн захиргааны төв байгууллага тооллого зохион байгуулж явуулахад дор дурдсан үүрэгтэй оролцоно:

15.1.1.гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаадад түр болон байнга оршин суугаа Монгол Улсын иргэдийн тооллогыг зохион байгуулж явуулах;

15.1.2.хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хилийн болон дотоодын цэргийн албан хаагчид, хоригдож буй сэжигтэн, яллагдагчийн тооллогыг зохион байгуулж

явуулах болон тооллогын явц дахь аюулгүй байдлыг хангах;

15.1.3.батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчдын тооллогыг зохион байгуулах.

15.2.Энэ хуулийн 15.1-д зааснаас бусад төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн салбарын үйл ажиллагаанд хамрагдах асуудлаар Улсын комиссоос гаргасан удирдамж, чиглэлийн дагуу тооллогыг зохион байгуулж явуулахад оролцох үүрэгтэй.

**16 дугаар зүйл. Тооллого зохион байгуулж явуулахад нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх, үүрэг**

16.1.Тооллого зохион байгуулж явуулахад бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дор дурдсан эрх, үүрэгтэй:

16.1.1.энэ хуулийн 6.3-т заасан зардлыг төсөвт тусгах;

16.1.2.энэ хуулийн 16.2-т заасан асуудлаар тухайн шатны Засаг даргын, тооллого явуулахтай холбогдсон асуудлаар харьяа тооллогын комиссын мэдээллийг сонсож, тулгамдсан асуудлыг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх;

16.1.3.орон нутагт тооллого зохион байгуулж явуулахтай холбоотой бусад асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

16.2.Тооллого зохион байгуулж явуулахад бүх шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга дор дурдсан үүрэгтэй оролцоно:

16.2.1.нутаг дэвсгэртээ тооллого явуулах бэлтгэл ажлыг хангах;

16.2.2.тооллого явуулахын өмнө хүн ам, өрхийн бүртгэлийн хөдөлгөөнийг бүрэн хийж, мэдээллийн санг бэлтгэх;

16.2.3.тооллогын асуудлаар Улсын комисс болон Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу тооллогын ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

16.2.4.тооллого явуулахтай холбогдуулан харьяа нутаг дэвсгэрийн гудамж, талбайн нэр, байр, орон сууцны хаягжилт, дугаарлалтыг цэгцлэх, тооллого явуулах нутаг дэвсгэрийн хил заагийг тогтоон, зураглал гаргах;

16.2.5.тооллогын комиссыг ажиллах болон тооллогын материалыг хадгалах байр, тавилга, шаардлагатай бусад тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах;

16.2.6.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

**17 дугаар зүйл. Тооллого зохион байгуулж явуулахад иргэдийн хүлээх үүрэг**

17.1. Тооллогод иргэд дор дурдсан үүрэгтэй оролцоно:

- 17.1.1. тооллогын асуулгад үнэн зөв, бүрэн хариулт өгөх;
- 17.1.2. тооллогын ажилтныг байр, орон сууцандаа нэвтрүүлэх;
- 17.1.3. тооллогод хамрагдсан тухай баримт бичиг тооллогын ажилтнаас авах.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

**18 дугаар зүйл. Тооллогын мэдээллийн нууцлал, хадгалалт, хамгаалалт**

18.1. Тооллогын мэдээлэл хуульд заасны дагуу хувь хүний нууцад хамаарах бөгөөд мэдээллийн нууцлалыг дор дурдсан хугацаанд задруулахыг хориглоно:

18.1.1. тооллогын ажилтан уг албан үүргээс чөлөөлөгдөх хүртэл;

18.1.2. тооллогын ажилтны албан үүргээс чөлөөлөгдсөн хувь хүн чөлөөлөгдсөнөөс хойш Архивын тухай хуулийн 25.8-д зааснаар уг мэдээллийг нийтэд ашиглуулахыг зөвшөөрөх хүртэл.

18.2. Тооллогын мэдээллийг Үндэсний статистикийн хороо Архивын тухай хуулийн 20.3, 20.4, 23.1.6-д заасны дагуу байгууллагын архивт хадгалж, мөн хуулийн 23.1-д заасны дагуу төрийн төв архивт шилжүүлнэ.

18.3. Үндэсний статистикийн хорооноос нийтэд ашиглуулах зорилгоор албан ёсоор боловсруулан нэгтгэснээс бусад хэлбэрээр хувь хүний холбогдолтой тооллогын мэдээллийг бусдад ашиглуулах, задруулахыг хориглоно.

18.4. Тооллогын мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, нийтэд мэдээлэлхтэй холбогдсон журмыг Үндэсний статистикийн хорооны дарга батлана.

**19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх харуцлага**

19.1. Тооллогын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

19.1.1. энэ хуулийн 16.2.2-16.2.5-д заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг шүүгч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

19.1.2. энэ хуулийн 17.1-д заасан үүргээ биелүүлээгүй иргэнийг статистикийн улсын байцаагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

19.1.3. энэ хуулийн 18.1-д заасныг зөрчиж нууцлалыг задруулсан этгээдийг шүүгч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос арван дөрөв хоног баривчлах;

19.1.4. энэ хуулийн 18.3-т заасныг зөрчсөн албан тушаалтныг шүүгч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос арван дөрөв хоног баривчлах.

**20 дугаар зүйл Хуулийг дагаж мөрдөх**

20.1. Энэ хуулийг 2008 оны 1 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

### СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Статистикийн тухай хуулийн 7, 12 дугаар зүйлд дор дурдсан хэсэг, заалт нэмсүгэй:

**1/ 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

"6. Хүн ам, орон сууцны улсын тооллого явуулахтай холбоотой харилцааг тусгай хуулиар зохицуулна."

**2/ 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

"4. Үндэсний статистикийн хороо нь дэргэдээ Статистик хөгжлийн сантай байж болно."

**3/ 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 23, 24, 25 дахь заалт:**

"23/улсын нийгэм, эдийн засгийн байдлын статистик мэдээллийг холбогдох яамдтай хамтран гаргаж, Улсын Их Хурлын сонгуулийг зарлахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө Улсын Их Хуралд мэдээлэх;

24/улсын хэмжээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн арга зүйг холбогдох байгууллагуудтай хамтран тогтоож мөрдүүлэх;

25-үлсын хүн ам саяар нэмэгдэх бүрд сая дахь иргэнийг бүртгэн баримтжуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчид мэдээлэх."

**2 дугаар зүйл.** Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт "Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна." гэсэн 2 дахь өгүүлбэр, 13 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн "дэд даргыг" гэсний өмнө "Тэргүүн дэд болон" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Статистикийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5, 8 дахь заалт, 5 дугаар зүйлийн 3, 6 дугаар зүйлийн 2, 7 дугаар зүйлийн 1- 5, 11 дүгээр зүйлийн 2-5 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн гарчиг, 1-3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн гарчиг, 1- 6 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн гарчиг, 1-3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн гарчиг, 1, 2 дахь хэсэг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5 дахь заалт, 15<sup>1</sup> дүгээр зүйлийн гарчиг, 1 дэх хэсэг, 16 дугаар

зүйлийн 1, 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 4, 19 дүгээр зүйлийн 1, 2, 4, 6, 20 дугаар зүйлийн 2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн "Үндэсний статистикийн газар" гэснийг тохиолдол бүрт нийцүүлэн "Үндэсний статистикийн хороо" гэж, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "а" заалтын "тооллогыг 10-аас илүүгүй жил тутам" гэснийг "ээлжит тооллогыг 10 жил тутам, завсрын тооллогыг 5 жил тутам" гэж, 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "1 дэх хэсэгт" гэснийг "1 дэх хэсгийн "а"-д зааснаас бусад хэсэгт" гэж, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "Засаг даргын санал болгосноор томилж" гэснийг "Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх" гэж, тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

### Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг сард 41400 төгрөгөөр өөрчлөн тогтоосугай.

2.Энэ тогтоолыг 2008 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 75 дугаар тогтоолыг 2008 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

### Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7.1.7, 22.1, 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Данзан-даржаагийн Туяа, Ухнаагийн Хүрэлсүх нарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Надмидын Баяртсайханыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Өлзийсайханы Энхтүвшинг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Сундуйн Батболдыг Төрийн байгуулалтын байнгын хорооны,

Улсын Их Хурлын гишүүн Доржийн Одбаярыг Хууль зүйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Цэгмидийн Цэнгэлийг Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2.Улсын Их Хурлын гишүүн Дэндэвийн Тэрбишдагвыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Эдийн засгийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Горчинсүрэнгийн Адъяаг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их



Хурлын гишүүн Рэнцэнгийн Будыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Цогтын Батааг Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Батболдыг Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатарыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Аухетайн Муратыг Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Ламжавын Гүндалайг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж Нийгмийн бодлого, боловсрол, соёл,

шинжлэх ухааны байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Санжаасүрэнгийн Оюуныг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Раднаабазарын Рашийг Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Жамъяндоржийн Батхуягийг Хууль зүйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

4. Энэ тогтоолыг батлагдсан өдөр буюу 2008 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

### Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:  
Улсын Их Хурлын гишүүн Д.Ганхуяг, Л.Гансүх, Ж.Гүррагчаа нараас 2007 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн "Олон улсын гэрээг Үндсэн хуульд нийцүүлэх тухай" УИХ-

ын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

### Улсын дээд шүүхийн Захиргааны танхимын тэргүүнийг томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн

саналыг үндэслэн Оросоогийн Зандрааг Улсын дээд шүүхийн Захиргааны танхимын тэргүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

### Хүнсний аюулгүй байдлыг хангах, архиан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүнсний тухай, Архиан согтуурахтай тэмцэх тухай, Химийн хорг болон аюултай бодисын

тухай зэрэг хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ,

Байгаль орчны сайд Г.Шийлэгдамба, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6.4-ийг хэрэгжүүлэх зорилгоор Үйлдвэр, худалдааны яамнаас баталсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тооны нормативийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хүнсний аюулгүй байдлыг хангах, аюулгүй хүнс хэрэглэх дадал, заншлыг хэвшүүлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллага, үйлдвэрлэгчдийн холбоодын дэмжлэгийг авч хамтран ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Архидан согтуурахтай тэмцэх тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлт батлагдах хүртэлх хугацаанд Архины үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нэмж олгохгүй байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Зар, сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа,

холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулан 7 хоногийн дараа Засгийн газарт оруулж хэлэлцүүлэхийг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил нарт даалгасугай.

6. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 14 хоногийн дотор боловсруулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргилд даалгасугай.

7. Эрх бүхий байгууллагын шинжилгээ, дүгнэлтээр хүний амь нас, эрүүл мэндэд хортой болох нь тогтоогдсон, стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны нэр төрөл, үйлдвэрлэгчийн тухай мэдээллийг саадгүй хүлээн авч, нийтэд шуурхай мэдээлж байхыг хэвлэл, мэдээллийн бүх байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /цаашид хууль гэх/ зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн гавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:

1. Хуулийн 10 дугаар зүйлд заасан гүйцэтгэх баримт бичгийн талаарх зарим зохицуулалтыг дараах байдлаар тайлбарласугай:

1.1. Энэ зүйлийн 10.1.1-д заасан "иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр" гэдэгт иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол хамаарна.

Мөн хэсгийн "шүүгчийн захирамж" гэдэгт зохигчдын эвлэрлийг баталгаажуулж, хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамжаас гадна хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

тухай хуулийн 74, 106 дугаар зүйл болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42, 43 дугаар зүйлд заасан шүүгчийн захирамж, шийдвэрийг хамааруулан ойлгоно.

1.2. Мөн зүйлийн 10.1.3-т заасан "шүүхээр баталгаажуулсан" гэж арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, эрх бүхий албан тушаалтны шийтгэвэр, цэргийн анги байгууллагын захирагч /дарга/-ийн тушаал зэргийг албадан гүйцэтгүүлэх талаар шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.3-т зааснаар шүүгчийн захирамж гаргасан байхыг хэлнэ.

1.3. Мөн зүйлийн 10.1.4-т заасан "торгох, эд хөрөнгө хураах ял ногдуулсан болон эд хөрөнгө, зардал гаргуулах, хохирол төлүүлэх" тухай асуудал нь эрүүгийн хэргийн талаар гарсан анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн магадлал, тогтоолд туссан байхын зэрэгцээ эдгээр нь шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заагдсан байж болно.

1.4. Мөн зүйлийн 10.1.5-д заасан "албан тушаалтны шийдвэр"-ийг хуулийн 48 дугаар зүйлийн 48.9-д заасан албадан дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч гаргах бөгөөд энэ нь бичгийн хэлбэртэй байна.

1.5. Мөн зүйлийн 10.3, 11 дүгээр зүйлд заасан "гүйцэтгэх баримт бичиг" гэдгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 187, 188 дугаар зүйлд заасан "гүйцэтгэх хуудас" гэж ойлгоно.

2. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасан "хөрөнгө битүүмжилсэн буюу хураасан акт, нэхэмжлэлийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээгээр иргэн, хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан баримт бичиг, тодорхойлолт" гэдэгт шүүхээс гарах шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэх боломжийг хангахын тулд шүүхийн шийдвэр гарахаас өмнө нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр эд хөрөнгийг бүгдийг буюу зарим хэсгийг битүүмжлэх, банканд дахь мөнгөн хадгаламжийн дансны зарлагын гүйлгээг зогсоох, тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах, эд хөрөнгөө захиран зарцуулах эрхийг хязгаарлах тухайлбал, эд хөрөнгийг худалдах, бусдад шилжүүлэх, эд хөрөнгийн бусад үүрэг биелүүлэхийг хориглох талаар гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын тогтоол, тэдгээрийн дагуу гүйцэтгэлийн ажиллагаа явуулсан акт, тэмдэглэл болон бусад холбогдох бичгийн баримтууд хамаарна.

3. Хуулийн 15 дугаар зүйлд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэлийн талаарх зохицуулалтыг дараах байдлаар тайлбарласугай:

3.1. Энэ зүйлийн 15.1.3-т заасан "хүсэлт гарсан бол түүнийг дахин шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарах хүртэл" гэснийг хүсэлт гарсан тохиолдолд түүнийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 181, Эрүүгийн байцаан шийдгэх хуулийн 362 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэх хүртэл гэж ойлгоно.

3.2. Мөн зүйлийн 15.2.3-т заасан "төлбөрийн шаардлага хангахуйц эд хөрөнгө" гэж төлбөр төлөгч төлбөр авахаас татгалзсан эд хөрөнгөөс өөр, төлбөрийг барагдуулахад хүрэлцэхүйц эд хөрөнгийг хэлнэ.

3.3. Мөн зүйлийн 15.2.4-т заасан "эрүүгийн журмаар хэргийг шалгаж байгаа" гэдэгт тухайн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэн, шалгаж байгааг ойлгоно.

3.4. Мөн зүйлийн 15.2.7-д заасан "шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон гүйцэтгэх баримт бичгийн талаар гомдол гаргасан нь үндэслэлтэй бол" гэж энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүхэд, эсхүл дээд шатны албан тушаалтанд гаргасан гомдлыг шүүх, эсхүл тухайн эрх бүхий этгээд үндэслэлтэй гэж үзсэн талаар шийдвэр, албан ёсны бичгийн баримт гаргасан байхыг хэлнэ.

3.5. Мөн зүйлийн 15.4-т заасан "мэдэгдэх" гэдэгт шийдвэр гүйцэтгэгч нь энэ хуулийн 15.1, 15.2-т заасан үндэслэл илэрсэн талаар бичгийн хэлбэртэй албан ёсны мэдэгдлийг шүүхэд, эсхүл ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргасан байхыг ойлгоно.

4. Хуулийн 16 дугаар зүйлд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох зохицуулалтыг дараах байдлаар тайлбарласугай:

4.1. Энэ зүйлийн 16.1.1-д заасан "төлбөр авагч нь төлбөр авахаас татгалзвал", мөн хуулийн 17.1.1-д заасан "төлбөр авагч хүсэлт гаргасан" гэдэгт гүйцэтгэх баримт бичигт заасан биелэгдээгүй төлбөрөөс, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулахыг, түүнчлэн тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгасныг гүйцэтгүүлэхээс бүрэн хэмжээгээр татгалзана гэж ойлговол зохино.

Мөн заалтын "хүсэлт", энэ зүйлийн 16.1.3-т заасан "тодорхойлолт" гэдэгт төлбөр авагч, эсхүл төлбөр төлөгч иргэний хүсэл зоригоо бичгийн хэлбэрээр илэрхийлж, гарын үсгээр баталгаажуулсан баримт, төлбөр авагч, эсхүл төлбөр төлөгч хуулийн этгээдийг төлөөлөх бүрэн эрхтэй этгээдийн гарын үсэг, тамга, тэмдэг бүхий албан ёсны баримтыг тус тус ойлгоно.

4.2. Мөн зүйлийн 16.1.4-т заасан "төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр авагч-иргэн нас барсан гэж зарлагдсан" гэдэгт Иргэний хуулийн 24 дүгээр зүйлд заасан үндэслэлээр иргэнийг нас барсан гэж зарласан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээс гадна, нас барсныг Иргэний бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу бүртгүүлснийг мөн хамааруулна.

Мөн заалтын "төлбөр-төлөгч хуулийн этгээд татан буугдсан" гэдэгт хуулийн этгээдийг Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.-32.1.5-д заасан үндэслэлээр татан буулгах шийдвэр гарч, татан буулгах комиссын ажиллагаа дуусгавар болж, бүртгэх байгууллага тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассан тухай нийтэд зарласан байхыг ойлгоно.

Харин "төлбөр төлөгч өөрчлөн байгуулагдсан" гэдэг нь хуулийн этгээдийг Иргэний хуулийн 31 дүгээр зүйлд заасан үндэслэлээр нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулсан тохиолдолд хамаарахгүй.

Мөн заалтын "тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжээгүй" гэж Иргэний хуулийн 123, 124, 520, 522 дугаар зүйлүүдэд зааснаар төлбөр төлөгч, эсхүл төлбөр авагчийн эрх, үүргийг залгамжлан авах этгээд байхгүй, түүнчлэн эрх залгамжлан авбал зохиц этгээд энэхүү эрх, үүргээс татгалзсан байхыг хэлнэ.

4.3. Мөн зүйлийн 16.1.6-д заасан "гүйцэтгэх баримт бичиг хүчингүй болсонд тооцогдсон" гэдэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд байгаа шүүхийн шийдвэр нь дээд шатны шүүхийн, бусад шийдвэр нь эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хүчингүй болсныг тус тус ойлгоно.

4.4. Худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагч төлбөртөө авахаас татгалзсан тохиолдолд төлбөр төлөгч уг эд хөрөнгөөс өөр эд хөрөнгө, банкинд мөнгөн хадгаламж болон харилцах дансанд мөнгөн хөрөнгө, орлогогүй болохыг шийдвэр гүйцэтгэгч холбогдох баримтаар тогтоосон бол энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 39 дүгээр зүйлийн 39.8, 48 дугаар зүйлийн 48.7-д заасны дагуу төлбөр авагчид гүйцэтгэх баримт бичгийг буцаана.

5. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан **"эрэн сурвалжилж болно"** гэдгийг энэ зүйлийн 18.1-д заасан ажиллагаа хийгдсэн боловч олдохгүй байгаа төлбөр төлөгч болон түүний эд хөрөнгийг байгаа газрыг илрүүлэхийн тулд төлбөр авагч өөрийн санаачилгаар, хувийн журмаар сураглаж, хайхыг хэлнэ. Ийнхүү эрэн сурвалжлахдаа төлбөр авагч нь шийдвэр гүйцэтгэх боловч цагдаагийн байгууллагын бүрэн эрхэд хамаарах ажиллагааг явуулж болохгүй.

6. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан **"бүх ажиллагаа"** гэдэгт энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан ажиллагааг ойлгоно.

7. Хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 67 дугаар зүйл, 68 дугаар зүйлийн 68.1, 75 дугаар зүйлийн 75.2-т тус тус заасан **"хариуцагч"** гэдэгт хариуцагчаас гадна гүйцэтгэх баримт бичигт заагдсан төлбөр төлөгч мөн хамаарна.

8. Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д **"бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд"**, 34 дүгээр зүйлийн 34.4-т **"гуравдахь этгээд"**, 47 дугаар зүйлийн 47.2.2-т **"бие даасан шаардлага гаргах эрхтэй өмчлөгч"**, **"нотолж чадах гуравдагч этгээд"**, 15 дугаар зүйлийн 15.1.2, 39 дүгээр зүйлийн 39.6, 71 дүгээр зүйлийн 71.1-д **"бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд"** гэж тус тус заасныг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улмаас эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн гэж үзэж байгаа төлбөр төлөгч болон төлбөр авагчаас бусад этгээдийг ойлгоно.

9. Хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан **"шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд бие даан оролцож болно"** гэдгийг 14-18 хүртэлх насны этгээд Иргэний хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д заасан үндэслэлээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцоход түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг авах шаардлагагүй гэж ойлгоно.

10. Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасан **"эрх залгамжлан авбал зохих этгээд"** гэдэгт төлбөр төлөгч иргэн нас барсан бол түүний эд хөрөнгийг өвлөн авсан этгээд, харин хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд татан буулгах комисс харилцагчдын шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгө болон тодорхой эрхийг авсан этгээдийг гэж тус тус ойлговол зохино.

11. Хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасан **"хуульд тусгайлан заасан"** гэдгийг Иргэний хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т зааснаар шүүхээр эрх зүйн бүрэн чадамжтай гэж тогтоогдсон, эсхүл мөн хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д зааснаар

бусдыг итгэмжлэлээр төлөөлж байгаа 18 нас хүрээгүй иргэнд хамааруулж хэрэглэнэ.

12. Хуулийн 34 дүгээр зүйлд шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны төрлийг зохицуулсан хэсэг, заалтыг дараах байдлаар тайлбарласугай:

**12.1.** Энэ зүйлийн 34.1.1-д заасан **"албадан барьцаалах үзэлшилд "барьцаалах" гэх"** гэдэг нь Иргэний хуулийн 13 дугаар бүлэгт заасан барьцааны эрхийн ойлголтод хамаарахгүй.

**12.2.** Энэ зүйлийн 34.1.4-т заасан **"бусдад байгаа өмч хөрөнгө"** гэдэгт төлбөр төлөгчийн өмчлөлийн боловч түүний биш, харин өөр этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа эд хөрөнгийг ойлгоно.

Мөн заалтын **"хуульд заасан журмын дагуу"** гэж хууль ёсны эзэмшигч, ашиглагчид байгаа төлбөр төлөгчийн эд хөрөнгийг зөвхөн хуульд заасан үндэслэл, зохицуулалтыг баримталж шаардахыг хэлнэ.

**12.3.** Мөн зүйлийн 34.2-т заасан **"үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эд хөрөнгийг бусдад шилжүүлсэн"** гэдэгт шүүхийн шийдвэрт тухайлан заасан үүргийн гүйцэтгэлийг хангах барьцааны эд хөрөнгийг төлбөр төлөгч өөр этгээдэд шилжүүлснийг ойлгоно.

13. Хуулийн 37 дугаар зүйлд заасан эд хөрөнгө үнэлэх тухай зарим зохицуулалтыг дараах байдлаар тайлбарласугай:

**13.1.** Энэ зүйлийн 37.1-д заасан **"үнэлж"** гэдэг нь хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураах ажиллагаа явуулахдаа шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийн чанар, хэрэгцээ, элэгдлийн байдал, төлбөр төлөгчийн санал, орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханш зэргийг харгалзан үнэлгээг акт /тэмдэглэл/-д тусгахыг хэлнэ.

**13.2.** Мөн зүйлийн 37.3-т заасан **"үнэлгээ тогтоосон өдрөөс хойш"** гэдгийг эд хөрөнгийг энэ зүйлийн 37.1-д зааснаар шийдвэр гүйцэтгэгч үнэлсэн тохиолдолд тэмдэглэл үйлдсэн үеэс, 37.2-т зааснаар шинжээч үнэлсэн тохиолдолд үнэлгээ гаргасан өдрөөс хойш гэж тооцно. Гомдол гаргах 7 хоногийн хугацааг үнэлгээ хийгдэхэд төлбөр төлөгч болон төлбөр авагч байлцсан бол энэ өдрөөс, байлцаагүй бол хуулийн 87 дугаар зүйлийн 87.3-т зааснаар мэдсэн өдрөөс хойш тоолно.

14. Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т заасан **"хүнсний болон хурдан гэмтэж муудах зүйлийг нэн даруй худалдана"** гэдгийг хадгалалтын тусгай нөхцөл шаарддаг, хадгалах хугацаа богино, амархан муудаж, чанараа алддаг хүнсний болон бусад барааг шийдвэр гүйцэтгэгч шууд хураан авч, тухайн зүйлийг эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа эсэхийг мэргэжлийн байгууллагаар хянуулж, баталгаажуулан энэ зүйлийн 39.1-д заасан хугацааг харгалзахгүйгээр худалдан борлуулах ажиллагаа хийхийг ойлгоно.

15. Хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д заасан **"анхны үнэ"** гэж Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1-д заасан журмын дагуу тогтоосон үнийг хэлнэ.

16. Хуулийн 48 дугаар зүйлд заасан албадан дуудлага худалдаа зохион байгуулах зарим зохицуулалтыг дараах байдлаар тайлбарласгай:

16.1. Энэ зүйлийн 48.1-д заасан “эд хөрөнгийн үнэ” гэдэгт хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1-д заасан үнийг ойлгох бөгөөд хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан үнэ үүнд хамаарахгүй.

16.2. Мөн зүйлийн 48.7-д заасан “албадан дуудлага худалдаа” гэдэгт анхны болон хоёр дахь дуудлага худалдааны аль нь хамаарна. Албадан дуудлага худалдаагаар борлогдоогүй эд хөрөнгийг төлбөртөө тооцон авахыг төлбөр авагчид санал болгохдоо дуудлага худалдаанд оруулсан үнийн дүнгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад гарсан зардлыг хасаж тооцно.

16.3. Мөн зүйлийн 48.9-д заасан “өмчлөх эрхийг шилжүүлсэн... тухай шийдвэр” гэж энэ хуульд заасан журмын дагуу явагдсан албадан дуудлага худалдаанд хамгийн өндөр үнэ амласан худалдан авагчийн буюу дуудлага худалдааны ялагчийн нэр, дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнэ, эд хөрөнгийн үнийг бүрэн төлсөн тухай болон өмчлөх эрх үүсэх үндэслэлийг тусгасан албадан дуудлага худалдааг эрхлэн хөтөлгөчийн гарын үсэг бүхий бичгээр үйлдсэн баримтыг хэлнэ.

Дуудлага худалдааны ялагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг хуульд заасан 2 долоо хоногийн хугацаанд бүрэн төлөөгүй бол түүнд эд хөрөнгийг шилжүүлэх, улмаар өмчлөх эрх үүсэх үндэслэлгүй талаар шийдвэрт тусгана.

Албадан дуудлага худалдаагаар борлогдсон эд хөрөнгийн үнийг бүрэн төлөөгүй тохиолдолд дуудлага худалдааны ялагчид өмчлөх эрх үүсэхгүй.

Мөн заалтын “албадан дуудлага худалдааг эрхлэн хөтөлгөчийн шийдвэрийг тухайн албадан дуудлага худалдааны үед... танилцуулна” гэдэг нь дуудлага худалдааны ялагч эд хөрөнгийн үнийг тэр дор нь төлсөн тохиолдолд албадан дуудлага худалдаа эрхлэн хөтөлгөөс гарсан шийдвэрт хамаарна.

Харин “албадан дуудлага худалдааг эрхлэн хөтөлгөчийн шийдвэрийг... товлон тогтоосон өөр хугацаанд танилцуулна” гэдэг нь дуудлага худалдааны ялагч эд хөрөнгийн үнийг тодорхой хугацааны дараа төлсөн тохиолдолд албадан дуудлага худалдаа эрхлэн хөтөлгөөс гарсан шийдвэрт хамаарна. Энэхүү хугацааг дуудлага худалдааны ялагч болон албадан дуудлага худалдаа эрхлэн хөтөлгөч хоёр харилцан тохиролцох боловч энэ хугацаа хуульд заасан 2 долоо хоногоос хэтрэхгүй байна.

Мөн заалтын “энэ хугацаа” гэдгийг албадан дуудлага худалдаа эрхлэн хөтөлгөөс шийдвэрийг танилцуулах болон дуудлага худалдааны ялагчаас эд хөрөнгийн үнийг төлөх хугацаа гэж ойлгоно.

16.4. Мөн зүйлийн 48.10-т заасан эрх нь албадан дуудлага худалдаа болсон өдөр буюу

албадан дуудлага худалдаа эрхлэн хөтөлгөчийн шийдвэр гарснаар үүсээгүй бол энэ зүйлийн 48.9-д заасан хугацаанд бий болно.

16.5. Мөн зүйлийн 48.11-д “гомдол гаргаагүй бол худалдан авагч үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болно” гэж заасны дагуу албадан дуудлага худалдаа эрхлэн хөтөлгөчийн шийдвэр гарч, эд хөрөнгийн үнийг төлсний дараа албадан дуудлага худалдааны ялагч Иргэний хуулийн 110 дугаар зүйлд зааснаар өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлсний дараа өмчлөгч болно. Харин тухайн шийдвэрт гомдол гарсан бол гомдлыг шийдвэрлэлт худалдан авагчид өмчлөх эрх үүсэхгүй.

17. Хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д заасан “төлбөр авагчийн шаардлага” гэдгийг хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5-д заасан шаардлага гэж ойлгоно.

18. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлж болохоор хуульд тусгайлан заасан бол үг тусгай зөвшөөрлийг шийдвэр гүйцэтгэгч хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5-д заасны дагуу битүүмжилж болно.

19. Хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан “тухайн байгууллага” гэж төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эрх, үүргийг залгамжлан авсан хуулийн этгээдийг хэлнэ.

20. Хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасан “хэсэгчлэн” гэдгийг их хэмжээний буюу төлбөрийг бүрэн төлөх чадваргүй этгээдийн эд хөрөнгийн байдалд үзлэг хийж, түүний эд хөрөнгө, мөнгө нь төлбөрийн шаардлагыг хангахад хурлцэхгүй байгаа тохиолдолд тухайн жилд гүйцэтгэж болох ажиллагааны хэмжээг тогтоож болохыг ойлгоно.

21. Хуулийн 83 дугаар зүйлд заасан зохицуулалт нь мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-т заасан гүйцэтгэх баримт бичгийн дагуу явагдсан шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарахгүй.

22. Хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-т “шүүхийн шийтгэх тогтоол гарснаас хойш” гэдгийг “шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш” гэж ойлгоно.

23. Мөн зүйлийн 91.7-д заасны дагуу шүүхээс хойшлуулсан 6 сарын хугацаа дуусахад торгуулийг төлөөгүй бол торгох ялыг хуулийн 92 дугаар зүйлд заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

24. Хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-д заасан “албадан гаргуулах” ажиллагааг Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлд заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ.

25. Хуулийн 95 дугаар зүйлийн 95.2-т заасан “түүний үнийг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлнэ” гэдгийг хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д зааснаар ойлгож хэрэглэнэ.

26. Хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1.3-т заасан “...ялтны тодорхойлолт...” гэж ялтны хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоохтой холбогдсон түүний

өвчин, эмгэгийн байдал, анатоми, морфологи, үйл ажиллагааны өөрчлөлт, алдагдал, бие махбод, мэдрэлийн системийн онцлогийн талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Тогтоол гүйцэтгэх газрын нэгдсэн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийг хэлнэ.

Мөн заалтын **"...эрүүл мэндийн зохих байгууллага..."** гэдэгт өвчтэй тухайн ялтны ял эдэлж байгаа хорих ангийн харьяалагдах аймаг, нийслэл, сум, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс"-ийг ойлгоно.

27. Хуулийн 115 дугаар зүйлийн 115.1.8-д заасан **"...бусад тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах"** гэдэгт шүүхийн шийтгэх тогтоол гарч, хорих ял эдлэхээс өмнө ялтан Нийгмийн даатгалын хууль тогтоомжд заасан болзол, журмын дагуу нийгмийн даатгалд даатгуулж, шимтгэл төлсөн, тэтгэвэр, тэтгэмж авах эрх нь үүссэн, тэтгэвэр, тэтгэмжээ авч байсныг хамааруулна.

Мөн заалтын **"...бусад тэтгэвэр..."** гэдэгт Нийгмийн даатгалын сангаас авах тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, ахмад настны халамжийн, дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх /50 насанд хүрсэн эцэг/-ийн халамжийн тэтгэвэр тус тус хамаарна.

Мөн заалтын **"...бусад тэтгэмж"** гэдэгт Нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний

болон амаржсаны, мөн нийгмийн халамжийн сангаас хөхүүл хүүхэдтэй эхэд олгох, түүнчлэн жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй эхэд олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тус тус хамааруулан ойлгоно.

28. Хуулийн 115 дугаар зүйлийн 115.1.6, 119 дүгээр зүйлийн 119.1-д тус тус заасан **"төрөл, садан"** гэдгийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-д зааснаар ойлгоно.

29. Хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д заасан **"харуул хамгаалалтгүй ажиллуулах"** гэж хорих анги, тэдгээртэй адилтгах байгууллага, цагдан хорих байрны ав ахуйн үйлчилгээнд хамгаалалтын бүсээс алслагдсан, харуул хамгаалалтын байнгын хяналт тавих боломжгүй хорих байгууллагын өөрийн объектод ажиллуулахыг хэлнэ.

30. Хуулийн 127 дугаар зүйлийн 127.6-д заасан **"жил"** гэдгийг сахилгын шийтгэл анх хүлээсэн өдрөөс хойш 12 сар гэж ойлгоно.

31. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Дээд шүүхийн 2003 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 11, 2006 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 35 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Б.УНДРАХ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн тухай /цаашид хууль гэх/ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.-т заасан **"олон хүүхэдтэй"** гэдгийг 4 ба түүнээс дээш хүүхэдтэй байхыг хамааруулан ойлгоно.

2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7.-д заасан **"тодорхой шалгуур, болзол"** гэж хуулийн 19 дүгээр зүйлд заасан тэтгэмж авах эрх бүхий

этгээдийн асрамжилж буй өндөр настан, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан тушаалаар батлагдсан "Өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх аргачлал"-ын дагуу "нэн ядуу", "ядуу" гэсэн ангилалд багтдаг, мөн хуулийн 21, 22 дугаар зүйлд заасны дагуу эмч, эмнэлгийн байгууллагын байнгын хяналтанд байдаг, бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүй болох нь энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.-т зааснаар Засгийн газраас тогтоосон журмаар тогтоогдсон байхыг хэлнэ.

3. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.-т заасан Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн **"сум, хорооны нутгийн захиргааны төлөөлөл"**

гэдэгт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10.-т заасан "...сум.... хорооны Засаг дарга", мөн зүйлийн 4.1.13.-т заасан "...сум.... хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид", "**иргэний нийгмийн төлөөлөгч**" гэдэгт тухайн нутаг дэвсгэрт ажиллаж, амьдарч байгаа иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг тус тус хамааруулна.

4.Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.-д заасан "**нийгмийн ажилтны боловсрол эзэмшсэн**" гэдгийг "**нийгмийн ажилтан**" мэргэжлээр Боловсролын болон Дээд боловсролын тухай хуулиудад зааснаар дипломын буюу бакалаврын сургалтаар дээд боловсрол эзэмшсэн байхыг ойлгоно.

5.Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.-т заасан "**дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй**" гэж тэжээн тэтгэх үүрэг бүхий эрэгтэй нь 60, эмэгтэй нь 55-аас дээш нас хүрэх, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй болох буюу тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгох зэргээр хөдөлмөрийн чадваргүй болсны улмаас "нэн ядуу" гэсэн ангилалд багтдаг тэжээн тэтгүүлэгч өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тэжээн тэтгэх, асран хамгаалах бололцоогүй болохыг хэлнэ.

Дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй байдал нь оршин суугаа газрын Засаг дарга, эрх бүхий байгууллагын тодорхойлолтоор тогтоогдсон байвал зохино.

6.Мөн зүйлийн 18.1.5.-д заасан "**4 ба түүнээс дээш хүүхэдтэй**" гэдэгт эх /эцэг/-ийн төрүүлсэн буюу үрчилсэн, түүний шууд асрамжид байгаа 0 – 16 насны 4 ба түүнээс дээш хүүхэд хамаарна.

Хүүхэд 16 насанд хүрэх, эсхүл бусдад үрчлэгдсэн тохиолдолд тэдгээрийг дээрх хүүхдийн тоонд оруулахгүй бөгөөд эцэг, эх нь эцэг, эх байх

эрхээ хасуулсан, хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр эцэг эхээс нь өөр хүнийг шүүхийн болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бол хуулийн энэ зохицуулалт эдгээр эцэг, эхэд хамаарахгүй.

7.Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2., 19.1.3.-т заасан "**асарч буй иргэн**" гэдэгт шүүхийн болон захиргааны байгууллагаас асран хамгаалагчаар албан ёсоор тогтоогдсон этгээдийг ойлгоно. Түүнчлэн бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүйн улмаас хүний амьдралын хэвшилд байнгын давтагдах, зайлшгүй хийгдвэл зохих үйлдлүүдийг хийж чадахгүй болсон нөхцөлд түүнд туслаж, дээрх үйлдлийг нөхөн гүйцэлдүүлэх үүрэг хүлээж, гүйцэтгэж байгаа нь энэ хуульд заасан журмын дагуу тогтоогдсон гэр бүлийн гишүүн, төрлийн болон садангийн, эсхүл хөндлөнгийн хүн, мөн өөрийн гэр бүлдээ авч асрамжилж буй аливаа иргэн үүнд нэгэн адил хамаарна.

8.Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.4.-т заасан "**түр байрлуулан асрамжлах**" гэж энэ зүйлийн 26.2.-т заасан этгээдийг хооллох, хонуулах, эмнэлгийн үзлэгт хамруулах, бусдын хүчирхийлэл, дарамтаас хамгаалах зэргээр түр хугацаагаар орон байраар хангаж, халамжлахыг хэлнэ.

9.Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.5.-д заасан "**гэрийн асрамжийн үйлчилгээнд хамруулах**" гэдэгт энэ хуульд заасан халамжийн болон бусад үйлчилгээг мөн зүйлийн 26.2.-т заасан этгээдэд түүний өөрийнх нь, эсхүл асрамжиндаа байлгаж байгаа этгээдийн орон гэрт үзүүлэхийг ойлгоно.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**
**С. БАТДЭЛГЭР**
**ШҮҮГЧ**
**Л. БЯМБАА**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

### ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Захиргааны хариуцлагын тухай хуулийн /цэцэгид "хууль" гэж зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн

15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь.

1 Хуулийн 10 дугаар зүйлд захиргааны хариуцлага хүлээлгэх харьяаллыг хоёр буюу

түүнээс дээш байгууллага, албан тушаалтанд ногдуулсан бол захиргааны зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг анх хүлээн авсан байгууллага, албан тушаалтан хянан шийдвэрлэнэ.

Харин нэг этгээд хоёр буюу түүнээс дээш төрлийн зөрчил гаргасан бөгөөд тэдгээрт шийтгэл ногдуулах эрхийг өөр өөр байгууллага, албан тушаалтанд олгосон бол зөрчил тус бүрийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хянан шийдвэрлэнэ.

**2. Захиргааны нэг төрлийн зөрчлийг давтан буюу удаа дараа үйлдсэн бөгөөд алинд нь ч хариуцлага хүлээгээгүй этгээдэд нэг шийтгэврээр, нэг төрлийн шийтгэл ногдуулах бөгөөд түүний хэмжээг тухайн төрлийн зөрчилд ногдуулж болох шийтгэлийн дээд хэмжээнээс хэтрүүлж болохгүй.**

**3. Захиргааны зарим зөрчилд "эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол" гэж заасныг тухайн зөрчил эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, эсхүл Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүй байхыг ойлгоно.**

**4. Хуулийн 19 дүгээр зүйлд захиргааны шийтгэл ногдуулсан шүүхийн шийтгэвэрт давж заалдах гомдол, албан тушаалтны шийдвэрт гомдол тус тус гаргах талаарх зарим зохицуулалтыг дараах байдлаар тайлбарласугай:**

**4.1 Энэ зүйлийн 2 дугаар хэсгийн 1-д "дээд шатны шүүхэд" гэж заасныг аймаг, нийслэлийн шүүхэд гэж ойлгох ба ийнхүү давж заалдах гомдол гаргахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170, 171 дүгээр зүйлүүдэд заасан гомдол гаргах, түүнийг хянан хэлэлцэх журам хамаарахгүй болно.**

Давж заалдах гомдлыг анхан шатны шүүх хүлээн авч, захиргааны зөрчлийн хэргийн хамт дээд шатны шүүхэд хүргүүлнэ. Гомдлыг хүлээн авах, бусад этгээдэд танилцуулах, хэргийг дээд шатны шүүхэд хүргүүлэх зэрэгт хэргийн хөдөлгөөний стандартад заасан нийтлэг хугацаа, журмыг баримтална.

**4.2 Мөн зүйлийн 3-т зааснаар зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах гомдол гаргахдаа захиргааны шийтгэл ногдуулсан шийтгэврийн биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргавал анхан шатны шүүхийн шүүгч захирамж гаргаж, гомдлыг хүлээн авсан өдрөөс хянан шийдвэрлэх хүртэл хугацаагаар шийтгэвэр биелүүлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.**

Торгуулийн хуудсаар торгууль ногдуулсанд давж заалдах гомдол гаргах нь захиргааны уг шийтгэлийн биелэлтийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

Торгох, эсхүл баривчлах захиргааны шийтгэл ногдуулсан шийтгэвэрт давж заалдах гомдол гаргахад өмнө хуулийн 20 дугаар зүйлийн 2-т зааснаар торгууль бүрэн, эсхүл хэсэгчлэн төлөгдсөн, эсхүл баривчлах шийтгэлийг эдлүүлж эхлэсэн бол шийтгэврийг биелүүлэх ажиллагааг түдгэлзүүлэхгүй.

Давж заалдах гомдлыг дээд шатны шүүх хянан хэлэлцэж, шийтгэврийг хэвээр үлдээсэн, эсхүл захиргааны шийтгэлийн төрлийг хэвээр үлдээж, зөвхөн хугацаа буюу хэмжээг өөрчилсөн бол шийтгэврийг биелүүлэх ажиллагааг шүүгчийн захирамжаар сэргээж, Цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

**4.3 Мөн зүйлийн 4-т зааснаар давж заалдах гомдлыг аймаг, нийслэлийн шүүх хянан хэлэлцэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.2., Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 309 дүгээр зүйлийн 309.1.-д заасан хугацаа хамаарахгүй бөгөөд гомдлыг хянан хэлэлцээд гаргасан магадлалд хяналтын гомдол гаргах журам энэ хуульд заагдаагүй тул давж заалдах шатны шүүхийн магадлал эцсийн шийдвэр байна.**

Давж заалдах шатны шүүх магадлал гаргахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудын зүйл, заалтыг удирдлага болгохгүй, харин энэ хуулийн болон Шүүхийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг баримтлана.





4.4 Албан тушаалтны шийтгэл ногдуулсан шийдвэрт энэ зүйлийн 2 дугаар хэсгийн 2-т заасны дагуу гаргасан давж заалдах гомдлыг тухайн салбарын дээд шатны албан тушаалтан хянан шийдвэрлэнэ. Уг шийдвэрийн талаар мөн зүйлийн 5-д зааснаар гаргасан гомдлыг энэ зүйлийн 1, 2-т заасан давж заалдах гомдол гэж үзэхгүй.

Харин тухайн албан тушаалтан болон байгууллагын харьяаллаас хамааран уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.-т зааснаар иргэний хэрэг үүсгэх үндэслэл болох гомдол, мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7.-д заасан захиргааны хэрэг үүсгэх нэхэмжлэл гэж тус тус үзнэ.

4.5. Мөн зүйлийн 6-д заасан "Иргэний байцаан шийтгэх хууль" гэснийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль гэж ойлгоно.

4.6. Захиргааны хариуцлагын тухай хуулиас өөр бусад хуульд зааснаар захиргааны шийтгэл

ногдуулсан шийтгэвэрт давж заалдах гомдол гаргавал энэ зүйлд заасан журам мөн адил хамаарна.

5. Хуулийн 31 дүгээр зүйлд "төрийн байгууллагын ажилтан" гэж заасныг Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.-д заасан төрийн албан тушаалтан гэж ойлгоно.

6. Хуулийн 36 дугаар зүйлд заасан "бага хэмжээ" нь Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.-д заасан "бага бус" хэмжээнээс доош байна.

7. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 1993 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 38 дугаар, Монгол Улсын Дээд шүүхийн 1994 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 177 дугаар тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

ЦАМАРСАЙХАН

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

### Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай

Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5-д заасан "... захиргааны удирдах албан тушаалтан ..." гэдэгт үйлдвэрийн газар, байгууллага, аж ахуйн нэгжийн ажил олгогчийн эрх эдлэхээр сонгогдож, томилогдсон

албан тушаалтнууд, даргын зөвлөлийн гишүүд, компаний удирдлагын багийн гишүүд, хоршооны тэргүүлэгчид, төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгах зөвлөлийн дарга, гишүүд хамаарна.

2. Мөн зүйл, хэсгийн "... үйлдвэрчний эвлэлийн сонгуульт ажил ..." гэдгийг бүх шатны үйлдвэрчний эвлэлүүдийн сонгуулиар хүлээсэн үүрэг гэж ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Д.ПУНЦАГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 255958  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 2